



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/82/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Ахл 3.02.25 № 01/126
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага тайлант онд нутгийн захиргааны байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн тусалцааг авахыг зөрчин нэмэлт санхүүжилтийн дансаар 7 аж ахуй нэгж, 5 иргэнээс 34,888.7 мянган төгрөгийн хандив тусламж авсан, баяр наадмын зардалд хандив тусламжаар 11,462.8 мянган төгрөг бүрдүүлж, хивс худалдан авахад 7,327.8 мянган төгрөг, баяр наадмын бусад зардалд 1,850.0 мянган төгрөг, төв түмний цэнгэл наадамд 2,285.0 мянган төгрөг нийт 11,462.8 мянган төгрөг зарцуулж нийт 46,351.5 мянган төгрөгийн зөрчил гаргасан нь гүйцэтгэлийн үе шатны материаллаг түвшнээс хэтэрсэн буюу санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/02 тушаалаар тушаалаар бүтэц орон тоо 22 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилт, хэрэгжүүлэх 34 арга хэмжээтэй баталснаас нийт 86,4%-тай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 90,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,949.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 130,929.2 мянган төгрөгийн барилга байгууламж, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн 56,309.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 105,872.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.
- Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Морьт Сүмбэр ХХК 8,498.0 мянган төгрөг, Шүтээн майнинг ХХК 1,350.0 мянган төгрөг, Октябрь сүмбэр ХХК 1,000.0 мянган төгрөг, Ев Хаш Аранга ХХК 5,000.0 мянган төгрөг, Голденсенд ХХК 8,040.7 мянган төгрөг, Нүүрс хими технологи ХХК 5,000.0 мянган төгрөг, нийт 28,888.7 мянган төгрөг, 5 иргэнээс 6,000.0 мянган төгрөг нийт 34,888.7 мянган төгрөгийн хандив тусламж авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,919,221.33	78,071,877.61
33	АВЛАГА	98,255.51	265,911.84
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	98,255.51	265,911.84
35	БАРАА МАТЕРИАЛ	70,820,965.82	77,805,965.77
354	Хангамжийн материал	70,820,965.82	77,805,965.77
35410	Бичиг хэргийн материал	871,000.00	871,000.00
35420	Аж ахуйн материал	14,422,700.00	14,422,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	329,000.00	329,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.05	00.00
35470	Бусад хангамжийн материал	55,198,265.77	62,183,265.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	505,599,110.46	848,134,508.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	505,599,110.46	848,134,508.19
392	Биет хөрөнгө	492,413,110.46	834,948,508.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	612,170,866.92	743,100,087.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-168,669,132.45	-204,021,049.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,718,314.00	243,527,404.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,923,314.17	-83,378,314.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,874,999.90	179,697,525.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,883,996.85	-66,122,098.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,544,290.47	42,544,290.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,763,765.21	-34,599,748.69
39209	Зам, гүүрийн байгууламж	536,275,430.00	536,275,430.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-534,675,743.32	-535,475,586.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,545,944.45	19,545,944.45
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,853,783.28	-6,198,377.64
39217	Ном	53,000.00	53,000.00
393	Биет бус хөрөнгө	13,186,000.00	13,186,000.00
39301	Програм хангамж	1,040,000.00	1,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,040,000.00	-1,040,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,186,000.00	13,186,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	576,518,331.79	926,206,385.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,248,255.51	1,150,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,248,255.51	1,150,000.00
413	Өглөг	1,248,255.51	1,150,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	98,255.51	00.00
4136	Бусад өглөг	1,150,000.00	1,150,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,150,000.00	1,150,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	575,270,076.28	925,056,385.80
51	Засгийн газрын хувь оролцоо	575,270,076.28	925,056,385.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	365,678,073.22	365,678,073.22
51101	Өмч: - төрийн	365,678,073.22	365,678,073.22
512	Хуримтлагдсан үр дүн	-38,840,072.40	310,946,237.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-38,840,072.40	-38,840,072.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	349,786,309.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,432,075.46	248,432,075.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	576,518,331.79	926,206,385.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	377,349,356.00	791,992,352.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,075,000.00	385,736,037.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,075,000.00	385,736,037.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,075,000.00	385,736,037.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,075,000.00	385,736,037.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	10,000,000.00	00.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	10,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,274,356.00	406,256,315.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,270,356.00	52,982,115.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,270,356.00	52,982,115.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	324,004,000.00	353,274,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	324,004,000.00	353,274,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	396,452,223.05	442,206,042.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,452,223.05	407,206,042.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,072,339.52	391,464,051.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,309,151.30	175,682,925.07
210101	Үндсэн цалин	139,521,649.79	154,238,944.58
210102	Нэмэгдэл	30,315,460.46	16,996,830.64
210104	Урамшуулал	00.00	4,447,149.85
210105	Гэрээт ажлын хөлс	32,472,041.05	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,128,427.09	16,810,650.94
210201	Тэтгэврийн даатгал	18,326,451.72	11,238,440.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,019,460.37	1,407,497.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,618,588.38	1,119,278.01
210204	Ажилгүйдлийн даатгал	374,529.59	261,257.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,789,397.03	2,784,177.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,397,570.08	32,649,362.79
210301	Гэрэл, цахилгаан	4,129,542.08	4,327,860.29
210302	Тулш, халаалт	27,687,528.00	27,741,002.50
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,956,500.00	23,044,310.05
210401	Бичиг хэрэг	2,551,792.00	1,560,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,700,000.00	18,437,710.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,708.00	1,298,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,200,000.00	1,747,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	144,800.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	144,800.00
2107	Томилго, зочны зардал	1,491,000.00	3,347,500.00
210702	Дотоод албан томилолт	1,491,000.00	3,347,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,615,806.00	40,604,153.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,365,806.00	38,918,522.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	756,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	302,000.00	301,130.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,673,885.05	99,180,349.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,803,920.00	51,029,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,791,965.05	48,150,439.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,379,883.53	15,741,991.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	5,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,641,991.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,641,991.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,379,883.53	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,379,883.53	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	35,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	35,000,000.00
221001	Их засвар	00.00	1,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	33,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19,102,867.05	349,786,309.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,075,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,075,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,075,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,177,867.05	349,786,309.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	367,424,356.00	406,256,315.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	367,424,356.00	406,256,315.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,420,356.00	52,982,115.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,270,356.00	52,982,115.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,150,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	324,004,000.00	353,274,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	324,004,000.00	353,274,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	352,895,256.00	363,756,315.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,895,256.00	363,756,315.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,515,372.47	348,014,323.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,309,151.30	167,903,686.62
210101	Үндсэн цалин	139,521,649.79	139,127,537.20
210102	Нэмэгдэл	30,315,460.46	21,709,629.97
210104	Урамшуулал	00.00	7,066,519.45
210105	Гэрээт ажлын хөлс	32,472,041.05	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,128,427.09	21,506,779.01
210201	Тэтгэврийн даатгал	18,326,451.72	14,823,834.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,019,460.37	1,692,277.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,618,588.38	1,340,381.91
210204	Ажилгүйдлийн даатгал	374,529.59	313,348.55
210205	Эрүүл мэндийн даатгал	3,789,397.03	3,336,936.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,397,570.08	32,980,172.79
210301	Гэрэл, цахилгаан	4,129,542.08	4,375,643.79
210302	Түлш, халаалт	27,687,528.00	28,024,029.00
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,956,500.00	21,305,500.00
210401	Бичиг хэрэг	2,551,792.00	1,275,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,700,000.00	13,215,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,708.00	1,504,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,200,000.00	5,310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,491,000.00	3,347,500.00
210702	Дотоод албан томилолт	1,491,000.00	3,347,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,917,926.00	39,147,130.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	667,926.00	37,798,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	302,000.00	301,130.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,814,798.00	60,323,555.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,736,798.00	60,323,555.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,379,883.53	15,741,991.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	5,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,641,991.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,641,991.03
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,379,883.53	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,379,883.53	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,529,100.00	42,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,529,100.00	42,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,529,100.00	42,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,529,100.00	42,500,000.00
221001	Их засвар	00.00	3,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	34,050,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,529,100.00	4,949,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,529,100.00	-42,500,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,502,973.06	-54,486,420.21	00.00	559,694,626.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,678,073.22	248,502,973.06	-54,486,420.21	00.00	559,694,626.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,308,259.50	00.00	-11,308,259.50
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-38,840,072.40	00.00	575,270,076.28
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-38,840,072.40	00.00	575,270,076.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-38,840,072.40	00.00	575,270,076.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	349,786,309.52	00.00	349,786,309.52
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	310,946,237.12	00.00	925,056,385.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	310,774,200.00	305,544,668.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,774,200.00	305,544,668.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,774,200.00	305,544,668.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,331,300.00	167,903,686.62
210101	Үндсэн цалин	139,059,300.00	139,127,537.20
210102	Нэмэгдэл	31,272,000.00	21,709,629.97
210104	Урамшуулал	-	7,066,519.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,039,000.00	21,506,779.01
210201	Тэтгэврийн даатгал	16,048,000.00	14,823,834.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,747,800.00	1,692,277.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,398,200.00	1,340,381.91
210204	Ажилгүйдлийн даатгал	349,500.00	313,348.55
210205	Эрүүл мэндийн даатгал	3,495,500.00	3,336,936.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,901,800.00	32,980,172.79
210301	Гэрэл, цахилгаан	4,665,000.00	4,375,643.79
210302	Түлш, халаалт	28,656,300.00	28,024,029.00
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,989,600.00	20,989,600.00
210401	Бичиг хэрэг	1,275,600.00	1,275,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,900,000.00	12,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,000.00	1,504,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,310,000.00	5,310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,347,500.00	3,347,500.00
210702	Дотоод албан томилолт	3,347,500.00	3,347,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,148,000.00	39,147,130.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,798,000.00	37,798,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	420,000.00	420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	302,000.00	301,130.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,517,000.00	18,169,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,517,000.00	18,169,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,500,000.00	42,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,500,000.00	42,500,000.00
221001	Их засвар	3,500,000.00	3,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	39,000,000.00	39,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	353,274,200.00	353,274,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,274,200.00	353,274,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	353,274,200.00	353,274,200.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	04	04
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,361,224.00	47,569,655.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,361,224.00	47,569,655.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,361,224.00	42,469,655.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	315,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	315,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,426.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370,426.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,990,798.00	42,153,755.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,912,798.00	42,153,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,361,224.00	52,982,115.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,361,224.00	52,982,115.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,361,224.00	52,982,115.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь нийтийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай хүргэж шууд ардчиллын зарчмыг баримталсан, мэдлэг чадварт суурилсан "Тунгалаг нутгийн захиргааны байгууллага" болох зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/02 тушаалаар тушаалаар бүтэц орон тоо 22 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилт, хэрэгжүүлэх 34 арга хэмжээтэй баталснаас нийт 86,4%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-ний, 2022 оны 7 дугаар сарын 01-ний, 2022 оны 8 дугаар сарын 29-ний, 2022 оны 12 дугаар сарын 9-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсэг батлах тухай" А/05 тушаалаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 8 арга хэмжээг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2020-2021 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Энэхүү баримт бичигт Засаг даргын тамгын газрын бүртгэл тайлагналын онцлогийг тусгасан 5 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 349,688.1 мянган төгрөгөөр бууу 60.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	98.3	265.9	167.6
Бараа материал	70,820.9	77,806.0	6,985.1
Үндсэн хөрөнгө	505,599.1	848,134.5	342,535.4
Нийт хөрөнгө	576,518.3	926,206.4	349,688.1
Өр төлбөр	1,248.3	1,150.0	98.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	575,270.1	925,056.4	349,786.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	576,518.3	926,206.4	349,688.1

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 98.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 167.6 мянган төгрөг буюу ажиллагсадтай холбоотой авлага 167.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 70,820.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 73,906.0 мянган төгрөг буюу худалдан авсан хөрөнгө 3,085.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 576,518.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 924,181.4 мянган төгрөг болж, 347,663.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 94,949.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 297,611.0 мянган төгрөг байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 90,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,949.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 130,929.2 мянган төгрөгийн барилга байгууламж, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн 56,309.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 105,872.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1,248.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,150.0 мянган төгрөг болж 98.2 мянган төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 924,181.4 мянган төгрөг болж 347,761.3 төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 348,948.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 310,774.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 42,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 353,774.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалтыг баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 353,274.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 353,274.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 5,229.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348,044.7 мянган төгрөг буюу 98,5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 5,031.7 мянган төгрөг, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 197.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	231,366.4	226,334.7	5,031.7	97.8
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	37,033.0	37,033.0	0.00	100.0
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	26,299.8	26,102.0	197.8	99.2
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-бусад хөрөнгийн зардал	42,500.0	42,365.0	0.00	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.00	100.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадмын зардал	5,000.0	5,000.0	0.00	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	765.0	765.0	0.00	100.0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал	5,310.0	5,310.0	0.00	100.0
	Дүн	353,274.2	348,044.7	5,229.5	98.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хөдөө аж ахуйн тооллогын зардал 3,348.7 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн тэтгэмжийн зардал 5,100.0 мянган төгрөг, шүлхий өвчний зардал 315.0 мянган төгрөг, ажил хайгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээ шатахууны зардал 66.0 мянган төгрөг, усны үнэ

2,958.7 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэнд 3,000.0 мянган төгрөг, байгаль нөхөн сэргээх барьцаа санд 3,200.0 мянган төгрөг, тендерийн хураамж 105.0 мянган төгрөг, иргэд, аж ахуй нэгж байгууллагаас хандив тусламжийн орлого 34,888.7 мянган төгрөг нийт 52,982.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил хайгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээ шатахууны зардалд 66.0 мянган төгрөг, ахмадын өргөөний тохижилтын зардалд 2,000.0 мянган төгрөг, баяр наадам, шагналын зардалд 18,344.3 мянган төгрөг, хөдөө аж ахуйн тооллогын зардалд 2,928.7 мянган төгрөг, өвс тэжээлийн зардалд 3,000.0 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн тэтгэмжийн зардалд 5,100.0 мянган төгрөг, цагдаагийн байр, маягт, хүүхдийн өрөөний засварт 4,950.0 мянган төгрөг, шатахууны зардалд 315.9 мянган төгрөг, зураг төсвийн үнэнд 3,000.0 мянган төгрөг, машины засварт 1,585.6 мянган төгрөг, томилолтын зардалд 420.0 мянган төгрөг, хогийн цэгийн ажилд 2,225.0 мянган төгрөг, худаг засварт 1,500.0 мянган төгрөг, модны үнэнд 2,000.0 мянган төгрөг, бусад зардалд 134.1 мянган төгрөг нийт 47,569.6 мянган төгрөг зарцуулж, 5,412.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 12 зорилт, хэрэгжүүлэх 34 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98,5%	353,274.2	348,044.7

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын ИТХ-аас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 353,274.2 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 3,532.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,472.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 89,4 хувь, 5,0 саяас дээших орлогын 18 гүйлгээ, зарлагын 2 гүйлгээ байршуулахаас 159,843.6 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Морьт Сүмбэр ХХК 8,498.0 мянган төгрөг, Шүтээн майнинг ХХК 1,350.0 мянган төгрөг, Октябрь сүмбэр ХХК 1,000.0 мянган төгрөг, Ев Хаш Аранга ХХК 5,000.0 мянган төгрөг, Голденсенд

ХХК 8,040.7 мянган төгрөг, Нүүрс хими технологи ХХК 5,000.0 мянган төгрөг, нийт 28,888.7 мянган төгрөг, 5 иргэнээс 6,000.0 мянган төгрөг нийт 34,888.7 мянган төгрөгийн хандив тусламж авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно”, 25.5.1-д “хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх;”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шатахууны үлдэгдэл төвлөрүүлээгүйтэй холбоотой 2 төлбөрийн акт, цахим төлбөрийн баримт, жижиг мөнгөн сан, шатахууны тооцоо бодолт, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой 4 албан шаардлага, өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 05/21 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,266.9	2	2,266.9	100
Албан шаардлага	4	104,593.2	4	104,593.2	100
Зөвлөмж					
Нийт дүн	6	106,860.1	6	106,860.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансаар хандив тусламж авсан эсэхийг авч үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 310,906.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 310,906.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: 1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайлангийн авлагын дүнгээс авлагын тодруулга тайлангийн дүн 132.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгаас санхүүжих төсвийн орлогыг 310,774.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 207,667.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,472.7 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 46,351.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 159,843.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Тус байгууллага тайлант онд хүнсний бараа материалд 1,472.7 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд баяр наадмын зардалд хандив тусламжаар 11,462.8 мянган төгрөг бүрдүүлж, хивс худалдан авахад 7,327.8 мянган төгрөг, баяр наадмын бусад зардалд 1,850.0 мянган төгрөг, төв түмний цэнгэл наадамд 2,285.0 мянган төгрөг нийт 11,462.8 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 7 аж ахуй нэгж, 5 иргэнээс 34,888.7 мянган төгрөгийн хандив тусламж авч зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно”, 25.5.1-д “хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 159,843.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн авлагын дүнгээс авлагын тодруулга тайлангийн дүн зөрүүтэй	1	132.6	1	132.6			1	132.6		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгаас санхүүжих төсвийн орлогыг дутуу тайлагнасан	1	310,774.2	1	310,774.2			1	310,774.2		
Дүн	2	310,906.8	2	310,906.8			2	310,906.8		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд хивс, баяр наадмын бусад зардал, төв түмний цэнгэл наадамд зарцуулсан.	1	11,462.8			1	11,462.8		
Тайлант онд төсвийн хөрөнгөөр дэлгүүрийн барааны өр барагдуулсан.	1	1,472.7	1	1,472.7				
Дүн	2	12,935.5	1	1,472.7	1	11,462.8		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 159,843.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ байршуулаагүй	1	159,843.6			1	159,843.6
Дүн	1	159,843.6			1	159,843.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 7 аж ахуй нэгж, 5 иргэнээс хандив тусламж авсан	1	34,888.7	1	34,888.7		
Дүн	1	34,888.7	1	34,888.7		
Нийт дүн	1	194,732.3	1	34,888.7	1	159,843.6

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn